СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САЛБАР ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аудитын код: ДА-202/04/-ҮА

2026 он

Агуулга	Хуудасны дугаар
Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн товьёг	2
Аудитын зорилго хамрах хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл	3-4
Ерөнхий мэдээлэл	4-9
Аудитын үр дүн	9
Аудитаар илрүүлсэн асуудал	9-11
Илрүүлсэн зөрчил	11-15
Дүгнэлт	16
Зөвлөмж	16-18

Товчилсон үгийн жагсаалт

ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практик олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
KPI	Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ДА	Дотоод аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
СХЗХ	Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс

Хүснэгтийн товьёг

д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хяналт шалгалтын төлөвлөгөө гүйцэтгэлийн	5
Хүснэгт 2	Мэдээллийн сангийн бүрдүүлэлт	6
Хүснэгт 3	Торгуулийн арга хэмжээ	7
Хүснэгт 4	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үзүүлэлт (Салбараар)	8
Хүснэгт 5	Хяналт шалгалтын үйл ажиллагааны цахим шилжилт, мэдээллийн аюулгүй байдал болон архивын бүрдүүлэлтэд хийсэн	9

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	*Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, хуваарийг тус тус үндэслэн дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ.*
Аудитын зорилт:	*Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс (цаашид аймгийн ЗДТГ-ын Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс хэлтэс гэх)-ийн үйл ажиллагаа нь төрийн үйлчилгээний чанар, хууль тогтоомжийн хэрэгжилт болон төсвийн үр ашигтай явагдаж байгаа эсэхийг магадлан шалгаж, эрсдэлийг илрүүлэх замаар удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.*
Аудитын хамарсан хүрээ:	*Аймгийн ЗДТГ-ын Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс 2024-2025 оны үйл ажиллагааг хамруулав.*
Аудитын арга зүй:	*Аудитыг ДАМПОУС 1100, 2010, 2310, 2420, 2500 стандартууд болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, ярилцлага, түүвэр шалгалт, харьцуулалт, статистик мэдээллийн дүн шинжилгээ, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ зэрэг арга зүйг ашиглан хийж гүйцэтгэв. Аудитыг ДАМПОУС болон улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.*
Аудитын шалгуур, үзүүлэлт:	*Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.Үүнд:* • *Төрийн албаны тухай хууль* • *Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль* • *Төсвийн тухай хууль* • *Төрийн хяналт шалгалтын тухай хууль* • *Төрийн болон албаны нууцын тухай хууль* • *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.* • *Захиргааны ерөнхий хууль* • *Зөрчлийн тухай хууль* • *Зөрчил шалган шийдвэрлэх тухай* • *Зөвшөөрлийн тухай хууль* • *Авлигын эсрэг хууль* • *Аюулгүй байдлын тухай хууль* • *Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль* • *Авто тээврийн тухай хууль* • *Авто замын тухай хууль* • *Байгаль орчны тухай хууль*

	• *Ашигт малтмалын тухай хууль* • *Түгээмэл тархацтай ашигт* • *Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль* • *Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль,* • *Малтмалын тухай хууль* • *Эрчим хүчний тухай* • *Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль* • *Газрын хэвлийн тухай хууль* • *Газрын тухай хууль* • *Гамшгаас хамгаалах тухай хууль* • *Барилгын тухай хууль* • *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль* • *Байгаль орчныг хамгаалах тухай хууль* • *Харилцаа холбооны тухай хууль* • *Шуудангийн тухай хуль* • *Радио долгионы тухай хууль* • *Өргөн нэвтрүүлгийн тухай хуул* • *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль* • *Цахим гарын үсгийн тухай хууль* • *Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль* • *Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль* • *Хөдөлмөрийн аюулгүй байдал,* • *Хөдөлмөрийн тухай хууль* *Эрүүл ахуйн тухай хууль болон эдгээртэй холбогдох, журам*
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	*Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор Д.Ванчигмаа 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.*

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Аудитын үндэслэл ба зорилго

Аймгийн Засаг даргын баталсан 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн удирдамж болон дотоод аудитын жилийн төлөвлөгөөний дагуу энэхүү аудитыг гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс (цаашид аймгийн ЗДТГ-ын Салбарын хяналтын зохицуулалтын хэлтэс гэх)-ийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг магадлах, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

1.2. Хэлтсийн чиг үүрэг, хамрах хүрээ

Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс нь төрийн хяналт шалгалтын тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжид заасны дагуу Засгийн газрын шийдвэр,

салбарын бодлого, хууль тогтоомжийн нийцэл, дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдаа зохион байгуулалтыг хангаж ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөн тус хэлтэс нь дэд бүтэц, худалдаа, үйлдвэрлэл, эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо, хүнс, хөдөө аж ахуй, хоршооны бодлого, барилга, нийтийн аж ахуйн бодлого, байгаль орчин, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.3. Бүтэц, зохион байгуулалт ба хүний нөөц

Аймгийн Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалаар хэлтсийн бүтцийг 2025 онд шинэчлэн 7 орон тоотойгоор баталсан. Тайлант хугацааны гүйцэтгэлээр 6 улсын байцаагч ажилласан байна. 2026 оны батлагдсан орон тоо 6 хэвээр байгаа боловч Монополын эсрэг газрын орон нутаг дахь улсын байцаагч " сул орон тоо нөхөгдөөгүй байгаа нь хүний нөөцийн бүрдүүлэлтэд анхаарал хандуулах шаардлагатайг илтгэж байна.

2.АУДИТЫН ҮР ДҮН

Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээг зөв хийсэн эсэх

2.1. Хяналт шалгалтын төлөвлөлт ба эрсдэлийн үнэлгээний нийцэл

2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад эрчим хүчний салбарт 13, авто зам, тээврийн салбарт 14, мэдээлэл, харилцаа холбооны салбарт 3, ***нийт 30 аж ахуйн нэгжийг*** хамруулсан байна. Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах, эрсдэлийн үнэлгээг тусгах шатанд дараах зөрчил, дутагдал илэрлээ.

Төлөвлөлт ба эрсдэлийн уялдаа: Хяналт шалгалтын удирдамж болон шалгах хяналтын хуудсан дахь эрсдэлийн үзүүлэлтүүд зөрүүтэй байна. Энэ нь стратегийн төлөвлөлтийн шатанд эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүрэн тусгаагүйгээс үүдэлтэй бөгөөд хяналтын нэгдмэл байдал, салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг алдагдуулж байна

Эрх зүйн эрсдэл: Хяналтын хуудас нь хяналт шалгалтыг стандартчилах эрх зүйн гол хэрэгсэл мөн. Гэвч хяналтын хуудсыг шинэчлэн баталгаажуулах санал хүргүүлээгүй байгаа нь шалгалтын үр дүнг хууль зүйн талаас баталгаажуулах боломжийг сулруулж, улмаар байцаагчийн шийдвэр эрх зүйн маргаанд өртөх эрсдэлийг бүрдүүлж байна.

Хамрах хүрээний эрсдэл: Эрсдэлийн үнэлгээгээр "Их эрсдэлтэй" ангилалд багтсан объектуудын хяналт шалгалтад хамрагдах хувь хангалтгүй байна.

Өндөр (Их) эрсдэлтэй объектуудын хяналт шалгалтын төлөвлөлт, хамралтын байдал (2024-2025 он)

Хүснэгт 1

Үзүүлэлтүүд	2024 он	2025 он	Өөрчлөлт (+/-)
Их эрсдэлтэй нийт объект	97	123	+26.8%

Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага	27	37	+10
Хамралтын хувь	27.8%	30.1%	+2.3%
Хяналтгүй үлдсэн (Үлдэгдэл)	70	86	+16
Үлдэгдлийн эзлэх хувь	72.2%	69.9%	-2.3%

Хяналт шалгалтын төлөвлөлтийн гүйцэтгэлийг эрсдэлийн ангилалтай харьцуулан үзэхэд өндөр эрсдэлтэй объектуудын хэсэг буюу дунджаар ***71 хувь нь хяналтын гадна үлдэж байгаа*** **нь** салбарын хэмжээнд зөрчил дутагдал хуримтлагдах, болзошгүй аюул ослыг цаг хугацаанд нь илрүүлж, таслан зогсоох боломжийг хязгаарлах бодит эрсдэлийг дагуулж байна. Энэ нь хяналт шалгалтын төлөвлөлт эрсдэлд суурилсан зарчмаар бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна.

2.2 Мэдээллийн сангийн бүрдүүлэлт Хяналтад хамрагдах объектуудын бүртгэл, ангилал үнэн зөв эсэх

2024-2025 оны тайлангийн хугацаанд хяналтын объектуудын бүртгэлжүүлэлт болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр дараах үр дүн тогтоогдов. Эрсдэлийн ангилал ба Нөөц хуваарилалт: Тайлант хугацаанд нийт **692** объектыг "Их", "Дунд", "Бага" эрсдэлийн зэрэглэлээр ангилж, мэдээллийн санд нэгтгэсэн байна. Ингэснээр хяналтын нөөцийг (хүн хүч, цаг хугацаа) эрсдэлд суурилан оновчтой хуваарилах арга зүйн суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Гүйцэтгэлийн зөрүү хэдийгээр объектуудыг ангилсан боловч бодит гүйцэтгэлээр "Их эрсдэлтэй" ангиллын объектуудын хяналтад хамрагдалт ердөө **30.1** хувьтай байна. Энэхүү үзүүлэлт нь мэдээллийн сангийн ангиллыг жилийн төлөвлөлттэй бодитой уялдуулах, эрсдэлийн удирдлагын механизмыг стратегийн түвшинд сайжруулах шаардлагатай байна.

Системийн шинэчлэл Авто зам ,тээврийн салбарт бүртгэл, хяналтын программ хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр өмнөх онуудын мэдээллийн давхардлыг арилгаж, бүртгэлийг бодит үзүүлэлтээр баталгаажуулан мэдээллийн чанарыг сайжруулсан байна

Мэдээллийн сангийн бүрдүүлэлт:

Хяналтын объектуудын цахим бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт

Хүснэгт 2

Салбарын чиглэл	2024 он (Цахим бүртгэл)	2025 он (Цахим бүртгэл)	Төлөв байдал
Мэдээлэл, холбоо	146 объект	165 объект	Бүрэн бүртгэгдэж, сан баталгаажсан.
Геологи, уул уурхай	-	77 объект	Шинээр бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн.
Авто тээвэр	109 объект	35 объект (шинэчилсэн)	Программ хангамж нэвтэрч, бүртгэл шинэчлэгдсэн.
Эрчим хүч	150 объект	10 объект (шинэчилсэн)	Төлөвлөгөөт бүртгэл, шинэчлэлийн шатанд

2.3 Хяналт шалгалтын үйл ажиллагаа: Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтуудын гүйцэтгэл, шийдвэр гаргалт мэргэжлийн дүгнэлтийн үндэслэл, ба

арга хэмжээний хэрэгжилт төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг шалгасан эсэх, торгуулийн хэмжээг хуульд заасан хязгаарт оногдуулсан эсэх,

Бодит байдал: (Хүний нөөцийн хүчин зүйл): Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн хүний нөөцийн бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь хяналт шалгалтын үйл ажиллагааг чанартай гүйцэтгэх, эрсдэлд суурилж төлөвлөх боломжийг хязгаарлаж байна. Хэлтсийн батлагдсан орон тоо бүрэн хангагдаагүй, ялангуяа Монополын эсрэг улсын байцаагчийн сул орон тоо нөхөгдөөгүй байгаа нь ажиллаж буй байцаагчдын ажлын ачааллыг норматив хэмжээнээс хэтрүүлэх үндсэн шалтгаан болж байна.

Ажлын ачаалал ба Гүйцэтгэлийн хамаарал: Хүний нөөцийн дутагдлаас шалтгаалсан ажлын хэт ачаалал нь улсын байцаагч нарыг хяналт шалгалтыг бодит эрсдэлд суурилж гүйцэтгэх бус, зөвхөн өөрийн нөөц бололцоо, цаг хугацаанд тулгуурлан "төлөвлөгөө биелүүлэх зарчмаар ажиллахад хүргэж байна. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт 5 объектод урьдчилан сэргийлэх хяналт хийж, зөрчлийн **82.8** хувийг арилгуулахаар төлөвлөсөн боловч бодит гүйцэтгэлээр албан шаардлагын биелэлт ердөө **56.7** хувьтай байгаа нь гүйцэтгэлийн хянан шалгалтын ба эргэх холбооны дутагдал байна.

Үр дагавар (Эрсдэл): Энэхүү нөхцөл байдал нь хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, баримтжуулалт зэрэг үндсэн процессуудад системлэг алдаа үүсэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна. Улмаар "Их эрсдэлтэй" ангиллын объектуудын 71 хувь нь хяналтын гадна үлдэж, төрийн хяналт шалгалтын үр нөлөө сууриар нь сулрах эрсдэлийг бүрдүүлсэн байна.

Торгуулийн арга хэмжээ

Хүснэгт 3

Салбар	Торгуулийн хэмжээ (төг)	Тайлбар
Геологи, уул уурхай	31,200,000	Салбарын хяналт шалгалтаар
Авто тээвэр	18,000,000	11 ААН-д ногдуулсан
Эрчим хүч	5,600,000	2024 онд 0.6 сая, 2025 онд 5.0 сая төгрөг
Авто зам	5,000,000	PIX засварын газарт (зам сэтэлсэн зөрчилд)
НИЙТ	59,800,000	

Зөрчлийн тухай хуулийн дагуу оногдуулсан торгуулийн арга хэмжээ нь эрх зүйн үндэслэлтэй байна. 2024–2025 онууд нийт 59.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

2.4 Дотоод хяналт ба эрсдэлийн удирдлага

Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн дотоод хяналтын тогтолцоо болон эрсдэлийн удирдлагын механизм үйл ажиллагааны бүх шатанд үр нөлөөтэй хэрэгжихгүй байна. Хүний нөөцийн дутагдал, улсын байцаагчдын ажлын хэт ачаалал болон эрх зүйн баримт бичгийн баталгаажуулалт удааширсан зэрэг хүчин зүйлс нь хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, баримтжуулалтын шатанд системлэг алдаа үүсэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж, хяналтын байгууллагын мэргэжлийн үнэлгээг эргэлзээтэй болгоход хүрчээ.

Үйл ажиллагааны тогтолцооны үл нийцэл ба Хүний нөөц: Хүний нөөцийн бүрдүүлэлт хангалтгүй (батлагдсан 7 орон тооноос 6 ажиллаж байгаа, сул орон тоо нөхөгдөөгүй) байгаагаас шалтгаалсан ажлын хэт ачаалал нь улсын байцаагч нарыг хяналт шалгалтыг бодит эрсдэлд суурилж гүйцэтгэх бус, зөвхөн өөрийн нөөц бололцоонд тулгуурлан *"төлөвлөгөө биелүүлэх"* зарчмаар ажиллахад хүргэж байна. Энэ нь хяналт шалгалтын үндсэн үйл явцад системлэг алдаа үүсэх суурь эрсдэлийг бий болгож, үнэлгээний бодит байдал алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Эрсдэлийн удирдлагын үр нөлөөгүй байдал: Байгууллагын эрсдэлийн үнэлгээ болон хяналт шалгалтын төлөвлөлтийн уялдаа холбоо алдагдсан байна. "Их эрсдэлтэй" ангиллын объектуудын тоо 2024 оноос *26.8 хувиар* өссөн боловч тэдгээрийн *69.9 хувь нь (86 объект*) хяналтын гадна үлдэж, төлөвлөгөөт хяналтад зөвхөн *30.1 хувь* нь хамрагдсан байна. Энэхүү үзүүлэлт нь эрсдэлийн удирдлага стратегийн түвшинд бодитой хэрэгжихгүй байгааг илтгэж байгаа бөгөөд хяналт шалгалтын нөөцийг (хүн хүч, цаг хугацаа) өндөр эрсдэлтэй салбар, объектуудад оновчтой хуваарилж чадахгүй байгаа системлэг дутагдлыг нотолж байна.

2.5. Архив. Албан хэрэг хөтлөлт, гомдол мэдээллийн шийдвэрлэлт, шалгалтын материалууд зохих журмаар иж бүрэн бүрдүүлж хадгаламжийн нэгж үүсгэсэн эсэх.

2024-2025 онуудын гүйцэтгэлийн тайлан, нэгтгэл болон төлөвлөгөөний баримтуудад үндэслэн үзэхэд архив, албан хэрэг хөтлөлтийн ажил зохих журмын дагуу хэрэгжиж байна. Хяналт шалгалт бүрээр хадгаламжийн нэгж үүсгэж, шалгалтын удирдамж, хяналтын хуудас, улсын байцаагчийн акт, албан шаардлага болон холбогдох бусад баримт бичгийг иж бүрэн бүрдүүлсэн байна. Цахимжуулалт 2025 онд шалгалтын материалыг цахим хэлбэрт шилжүүлж, нэгдсэн санд байршуулан архивт хүлээлгэн өгсөн нь мэдээллийн хадгалалт, хамгаалалтын стандартыг хангасан. Баримтжуулалтын чанар шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, зөрчил явцыг гэрэл зураг болон бусад нотлох баримтаар баяжуулан хадгаламжийн нэгжид хавсаргасан байна

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үзүүлэлт (Салбараар)

Хүснэгт 4

Салбарын чиглэл	Ирсэн өргөдөл, гомдол	Шийдвэрлэсэн	Шийдвэрлэлтийн хувь
Эрчим хүч	4	4	100%
Мэдээлэл, холбоо	2	2	100%
Геологи, уул уурхай	14	14	100%
НИЙТ	**20**	**20**	**100%**

- *Эрчим хүчний хяналт: 2024 онд Засгийн газрын "11-11" төв болон "7036-1111" дугаараар ирсэн 4 гомдлыг хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэж, хариуг 100 хувь хүргүүлсэн.*
- *Мэдээлэл, холбооны хяналт: 2025 онд ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүрэн шийдвэрлэж (100%), шалгалтын материалыг цахим архивт хүлээлгэн өгсөн.*

- *Геологи, уул уурхай: Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.*

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ зөвхөн хариу өгөхөөр хязгаарлалгүй, шалгалтын мөрөөр бодит арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулсан байна. Тухайлбал, 2025 онд ирсэн гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, илэрсэн зөрчилд торгууль ногдуулан, хохирлыг арилгуулсан баримтууд архивт бүрэн тусгагджээ. Архив, албан хэрэг хөтлөлт болон өргөдөл гомдлын шийдвэрлэлт нь "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

2.6. Мэдээллийн аюулгүй байдал: Цахим сангийн ашиглалт, нууцлалын хадгалалт.

Салбарын хяналтад төрөлжсөн систем болон 'Шилэн хяналт'-ыг нэвтрүүлсэн нь засаглалын ил тод байдлыг хангаж, өгөгдөлд суурилсан хяналтын эхлэлийг тавьсан байна .Технологийн дэвшил хяналт шалгалтын төрөлжсөн системд **315** объектыг эрсдэлийн үнэлгээнд хамруулсан нь хяналтыг өгөгдөлд суурилан гүйцэтгэх суурийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Цахим шилжилт болон мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээ

Хүснэгт 5

Удирдамжийн үзүүлэлт	Одоогийн байдал (Ололт амжилт)	Үр нөлөө, ач холбогдол
Системийн ашиглалт	Салбарын хяналтад ERP болон Road Estimator системийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж хэвшсэн. Эрчим хүч, Холбооны салбарын 315 объектын эрсдэлийн үнэлгээг системд бүртгэсэн.	Системүүдийн хооронд өгөгдөл автоматаар дамжихгүй байгаагаас мэдээллийг гараар давхар оруулах шаардлага үүсэж, ажиллагаан нэмэгдүүлж байна.
Ил тод байдал	shilen.gov.mn (Шилэн хяналт) цахим хуудсанд хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж, торгуулийн мэдээллийг тогтмол, нээлттэй байршуулж байна.	ил тод байдал нь хяналт шалгалтын үйл явцыг аливаа ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, шийдвэр гаргах түвшний хариуцлагыг өндөржүүлэх бодит хөшүүрэг болж байна."
Цахим архив	Хяналтад хамрагдах объектуудын мэдээллийн сан баяжиж, 2025 онд шалгалтын материалыг цахим хэлбэрт шилжүүлэн архивт хүлээлгэн өгсөн.	Энэхүү цахимжуулалт нь мэдээллийн эргэх холбоог сайжруулж, түүхэн өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийх, хяналт шалгалтын үйл явцыг шуурхай нөхөн шалгах боломжийг бүрдүүлсэн засаглалын чухал дэвшил болж байна."
Мэдээллийн аюулгүй байдал	Хандах эрхийн зохицуулалтыг байцаагч бүрийн албаны эрхээр хязгаарлаж, хөндлөнгийн оролцооноос сэргийлсэн.	Улсын байцаагчдыг тоон гарын үсэгт шилжүүлэх бэлтгэл хангагдаж, цахим баримтын хууль зүйн баталгаа болон засаглалын үр ашиг нэмэгдэхээр байна.

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

1. Хяналт шалгалтын төлөвлөлт ба эрсдэлийн үнэлгээний нийцэл

Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээний үр дүнг стратегийн түвшинд бүрэн тусгаагүй, төлөвлөлт болон гүйцэтгэлийн уялдаа холбоо хангалтгүй байгаа зөрчил тогтмолжсон.

Төлөвлөлт ба эрсдэлийн уялдаа: Хяналт шалгалтын удирдамж болон шалгах хяналтын хуудсан дахь эрсдэлийн үзүүлэлтүүд зөрүүтэй байна. Энэ нь стратегийн төлөвлөлтийн шатанд эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүрэн тусгаагүйгээс үүдэлтэй бөгөөд хяналтын нэгдмэл байдал, салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг алдагдуулж байна

Стратегийн төлөвлөлтийн сул тал: Жилийн төлөвлөгөө боловсруулах шатанд эрсдэлийн үнэлгээний үр дүнг суурь үзүүлэлт болгож ашиглаагүй.

Баримт бичгийн боловсруулалтын нэгдмэл бус байдал: Хяналт шалгалтын удирдамжийг боловсруулахдаа тухайн салбарын шалгах хяналтын хуудсанд заагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдтэй тулгаж нийцүүлээгүй.

Дотоод хяналтын механизм сул: Төлөвлөгөө болон удирдамжийг эрсдэлд суурилсан эсэхийг хянаж, баталгаажуулах хэлтсийн дотоод хяналт хангалтгүй байсан.

2. Хяналтын баримт бичгийн эрх зүйн чадамжийн дутагдал"

Эрх зүйн эрсдэл: Хяналтын хуудсыг шинэчлэн баталгаажуулах санал хүргүүлээгүй байгаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох салбарын дүрмүүдийг зөрчиж, шалгалтын үр дүнг хууль зүйн талаас баталгаажуулах боломжийг сулруулж, байцаагчийн шийдвэр эрх зүйн маргаанд өртөх эрсдэлийг бүрдүүлж байна.

- *Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй: "Төрийн хяналт шалгалтын тухай хууль" болон салбарын дүрмүүдээр хүлээсэн хяналтын хуудсыг шинэчлэх, баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлээгүй.*
- *Удирдлагын хяналт сул: Хяналт шалгалтын баримт бичгийг стандартчилах, эрх зүйн орчныг шинэчлэх талаар дээд шатны байгууллагад санал хүргүүлэх ажлыг орхигдуулсан.*
- *Мэргэжил арга зүйн уялдаа сул: Салбарын шинэчлэгдсэн стандарт, дүрэм журмыг хяналт шалгалтын үндсэн хэрэгсэл болох "шалгах хяналтын хуудас"-нд тухай бүр тусгаж хэвшээгүй.*

3.Өндөр эрсдэлтэй объектын хяналтын хамралт хангалтгүй зөрчил

Хамрах хүрээний эрсдэл: Эрсдэлийн үнэлгээгээр "Их эрсдэлтэй" ангилалд багтсан объектуудын хяналт шалгалтад хамрагдах хувь хангалтгүй (2025 онд 30.1%) байна. Нийт их эрсдэлтэй объектуудын 69.9% буюу 86 объект хяналтын гадна үлдэж, зөвхөн төлөвлөгөө биелүүлэхэд чиглэсэн хяналт хэрэгжиж байна.

Эрсдэлд суурилсан төлөвлөлтийн дутагдал: Жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээний үр дүнг стратегийн түвшинд ашиглаж, нөөцийг (цаг хугацаа, хүн хүч) өндөр эрсдэлтэй объектууд руу чиглүүлээгүй.

Тоон үзүүлэлтэд тулгуурласан хандлага: Хэлтсийн үйл ажиллагааг бодит эрсдэлээс урьдчилан сэргийлэх бус, зөвхөн батлагдсан төлөвлөгөөт шалгалтын тоог биелүүлэхэд чиглүүлж ажилласан.

- *Нөөцийн оновчгүй хуваарилалт: Хүний нөөц болон төсөв санхүүгийн боломжийг "Их эрсдэлтэй" гэж үнэлэгдсэн 86 объектыг шалгахад давуу эрх олгож хуваарилаагүй.*
- *Мэдээллийн сангийн ашиглалт сул: Нийт 692 объектыг эрсдэлээр ангилсан мэдээллийн сантай боловч түүнийг хяналт шалгалтын хамрах хүрээг тогтоохдоо шийдвэр гаргах түвшинд ашиглаж хэвшээгүй.*

4. Хүний нөөцийн удирдлага ба ажлын ачааллын зохицуулалт:

- *Хэлтсийн хүний нөөцийн бүрдүүлэлт дутуу, орон тооны төлөвлөлт болон гүйцэтгэлийн уялдааг хангаагүйгээс үйл ажиллагааны чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдсэн.*
- *Сул орон тоо ба ачаалал: Батлагдсан 7 орон тооноос "Монополын эсрэг газрын орон нутаг дахь улсын байцаагч"-ийн сул орон тоо нөхөгдөөгүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж, ажиллаж буй байцаагч нарт ажлын хэт ачаалал үүсгэсэн.*
- *Гүйцэтгэлийн чанар: Хүний нөөцийн дутагдлаас шалтгаалж байцаагч нар бодит эрсдэлд суурилж ажиллахаас илүүтэй, зөвхөн төлөвлөгөөт тоон үзүүлэлт биелүүлэх зарчмаар ажиллаж, хяналтын чанарыг орхигдуулсан.*

5. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын дутагдал:

Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчил тогтмолжсон.

- *Төлөвлөлтийн арга зүйн алдаа: Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээний үр дүнг стратегийн түвшинд суурь үзүүлэлт болгож ашиглаагүй.*
- *Эрх зүйн баримт бичгийн хоцрогдол: Хяналтын хуудсыг шинэчлэн баталгаажуулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлээгүй, стандартчилаагүй.*
- *Дотоод хяналтын механизм бүрдээгүй: Хэлтсийн хэмжээнд дотоод хяналтын тусгайлсан журам баталж мөрдүүлээгүй, эрсдэлийн бүртгэл хөтлөх тогтолцоогүй.*
- *Хүний нөөцийн дутагдал: Батлагдсан 7 орон тооноос 1 нь (Монополын эсрэг улсын байцаагч) сул байгаагаас ажлын хэт ачаалал үүсэж, хяналтын чанарт сөргөөр нөлөөлсөн.*
- *Тоон үзүүлэлтэд тулгуурласан хандлага: Байцаагч нар эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд бус, зөвхөн төлөвлөгөөт "тоон үзүүлэлт" биелүүлэхэд чиглэж ажилласан.*
- *Дотоод соёлын дутагдал: Дотоод хяналтыг зөвхөн хяналт-шинжилгээний нэгжийн ажил мэтээр үзэж, хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааны "хяналтын соёл" болж хэвшээгүй.*

4. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс нь холбогдох салбаруудын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг гүйцэтгэсэн боловч батлагдсан орон тоо бүрэн хангагдаагүй, хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан байцаагчдын ажлын ачаалал норматив хэмжээнээс хэтэрч, дотоод хяналтын тогтолцоо суларсан байна. Энэхүү нөхцөл байдал нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөлт, баримт бичгийн эрх зүйн нийцэл болон гүйцэтгэлийн удирдлагын үр нөлөөг сулруулахад голлон нөлөөлж байгааг тогтоолоо.Үүнд:

Илэрсэн асуудал 3.1	Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн үйл ажиллагаанд. Аудитын шалгалтаар дотоод хяналтын тогтолцоо **хангалтгүй** түвшинд байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал: Үндсэн дүгнэлтүүд:

- *Эрсдэлд суурилсан төлөвлөлт сул: Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээний үр дүнг стратегийн түвшинд бүрэн тусгаагүй, төлөвлөлт болон гүйцэтгэлийн уялдаа холбоо хангалтгүй байна.*
- *Хяналтын хамралт хангалтгүй: "Их эрсдэлтэй" гэж үнэлэгдсэн объектуудын дийлэнх хувь нь хяналтын гадна үлдсэн байна. Тухайлбал, 2024 онд их эрсдэлтэй объектуудын 27.8%, 2025 онд 30.1% нь л төлөвлөгөөт хяналтад хамрагджээ.*
- *Баримт бичгийн зөрүү: Шалгалтын явцад ашиглагдаж буй удирдамж болон шалгах хяналтын хуудас дахь эрсдэлийн үзүүлэлтүүд хоорондоо зөрүүтэй байгаа нь хяналтын нэгдмэл байдлыг алдагдуулж байна.*
- *Эрх зүйн баталгаажуулалт удаашралтай: Шинэчилсэн хяналтын хуудас, эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг эрх бүхий байгууллагаас баталгаажуулаагүй байгаа нь хяналт шалгалтын хууль ёсны байдалд эрсдэл учруулж байна.*
- *Мэдээллийн сангийн бүрдүүлэлт: Салбар бүрээр мэдээллийн сан үүсгэх, цахим бүртгэлд шилжих ажил ахицтай байгаа боловч эрчим хүчний салбарт шинэчлэлийн явц бусад салбартай харьцуулахад удаашралтай байна.*

Байх ёстой шаардлага /шалгуур/: *Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.3.1-д. "6.2.3.1. "үр дүнтэй" - зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь", Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-ын 1 дэх хэсэгт "хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш бол "үр дүнтэй", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5. Энэхүү журмын 1.4-т заасныг бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө батлан мөрдөнө. 3.1. Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ*

Асуудлын үндсэн шалтгаан: *Дотоод хяналтыг зөвхөн хяналт шинжилгээ, үнэлгээний газрын ажил гэж үзэж, хэлтсийн дотоод соёл болгож хэвшүүлээгүй.*

Хэлтэст үзүүлэх нөлөө /үр дүгэвэр/: *Алдаа зөрчил давтагдах, үйл ажиллагааны үр дүн хангалтгүй гарах (79.1%).*
Зөвлөмж: *1. 2026 оны III улиралд Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг боловсруулах асуудлаар санал боловсруулж хүргүүлэх.* *2. Хэлтсийн үйл ажиллагаанд дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг тайлагнах тогтолцоог бүрдүүлэх.* *3. 2026 оны II улиралд багтаан Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн эрсдэлийн бүртгэлийг баталж, улирал тутам шинэчлэгдэг тогтолцоог нэвтрүүлэх,*

Илэрсэн асуудал 3.2	*Эрсдэлийн шалгуур үзүүлэлт, шалгах хяналтын хуудас, удирдамж болон төлөвлөгөө хоорондын уялдаа хангалтгүй, эрсдэлийн ангиллыг бодит баримт, нөхцөл байдалд тулгуурлан нэг мөр үнэлэгдэгүйгээс өндөр эрсдэлтэй объектыг дутуу үнэлэх, хяналт шалгалтын нөөцийг буруу хуваарилах, шалгалтын үр нөлөө сулрах эрсдэлтэй*
Асуудлын ангилал	*Нөлөө Их*
Бодит байдал: ***Төлөвлөлт ба эрсдэлийн уялдаа: Төлөвлөлт ба эрсдэлийн уялдаа:*** *Хяналт шалгалтын удирдамж болон шалгах хяналтын хуудсан дахь эрсдэлийн үзүүлэлтүүд зөрүүтэй байна. Энэ нь стратегийн төлөвлөлтийн шатанд эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүрэн тусгаагүйгээс үүдэлтэй бөгөөд хяналтын нэгдмэл байдал, салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг алдагдуулж байна*	
Байх ёстой шаардлага /шалгуур/: *Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1.2-т "хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах бөгөөд . хараат бус, шударга, нээлттэй, ил тод байх", 4.1.5-д "хяналт шалгалтыг төлөвлөхдөө тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэх", 5^5.1-д "хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна", Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5.19-д "хяналт шалгалтын төлөвлөгөө, эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудас боловсруулах, батлах, эрсдэлийн ангилалд хамааруулахтай холбогдсон нийтлэг журам, арга члалыг Засгийн газар батална" гэж тус тус заасан*	
Асуудлын үндсэн шалтгаан: *Хяналт шалгалтын эрх зүйн баримт бичгийг баталгаажуулах шат дамжлага дахь шийдвэр гаргалтын удаашрал болон байгууллага хоорондын уялдаа холбоо сул байгаа нь хяналтын шинэ стандартыг мөрдөж эхлэх боломжийг хязгаарлаж байна.*	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: *Эрсдэлд суурилсан төлөвлөлт болон хяналтын нэгдмэл стандарт алдагдсанаар өндөр эрсдэлтэй объектуудад зөрчил, аюул осол хуримтлагдах, байцаагчийн шийдвэр эрх зүйн маргаанд өртөх бодит эрсдэлийг бүрдүүлж байна.*	
Зөвлөмж :2024-2025 оны тайланд дурдагдсан "Их эрсдэлтэй" объектуудын хяналтгүй үлдэж буй байдал (70 орчим хувь) болон эрх зүйн эрсдэлийг арилгахын тулд 2026 оны хагас жилийн төлөвлөгөөний биелэлтээс өмнө хяналтын хуудсыг шинэчлэн баталж, төлөвлөлтийн зөрүүг засах шаардлагатай.	

Илэрсэн асуудал 3.3	***Хяналт шалгалтын дүнгээс системийн шинжтэй асуудлыг нэгтгэн дүгнэж, журам, заавар, арга члал, эрх зүйн орчныг***

	боловсронгуй болгох санал болгон ашиглаагүйгээс нэг ижил зөрчил давтагдах, хяналт шалгалтын үр ашиг буурах, илэрсэн асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэх боломж алдагдах эрсдэлтэй.
Асуудлын ангилал	*Нөлөө Их*

Бодит байдал: *2024-2025 онуудад Хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шалгах хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулж, холбогдох эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хамт санал хүргүүлсэн боловч эрх бүхий байгууллагаас эцсийн шийдвэр ирээгүй, баталгаажуулаагүй байна.*

Асуудлын үндсэн шалтгаан: *Хяналт шалгалтын эрх зүйн баримт бичгийг баталгаажуулах шат дамжлага дахь шийдвэр гаргалтын удаашрал болон байгууллага хоорондын уялдаа холбоо сул байгаа нь хяналтын шинэ стандартыг мөрдөж эхлэх боломжийг хязгаарлаж байна."*

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: *"Шалгах хяналтын хуудсыг шинэчлэн баталгаажуулаагүй нь хяналт шалгалтын үр дүнг хууль зүйн талаас баталгаажуулах боломжийг сулруулж, байцаагчийн шийдвэр эрх зүйн маргаанд ертөх болон системийн шинжтэй зөрчил давтагдах бодит эрсдэлийг бүрдүүлж байна.*

Зөвлөмж: *Хяналт шалгалтын төлөвлөлтийг эрсдэлийн үнэлгээний үр дүнтэй стратегийн түвшинд уялдуулан, шалгах хяналтын хуудсыг шинэчлэн баталгаажуулах замаар 'Их эрсдэлтэй' ангиллын объектуудын хяналтын хамралтыг нэмэгдүүлж, эрх зүйн болон үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах.*

<u>Илэрсэн асуудал 3.4</u>	*Орон тоо дутуу, байцаагчийн ажлын ачаалал өндөр, хяналт шалгалтын хамрах хүрээ болон баримтжуулалтын чанар буурах нөхцөл үүссэнээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын хэрэгжилт саатах, өндөр эрсдэлтэй объект хяналтын гадна үлдэх, гүйцэтгэлийн чанар сулрах эрсдэлтэй.*
Асуудлын ангилал	*Нөлөө дунд*

Бодит байдал: *Хяналтын байгууллагын хүний нөөцийн дутагдал болон байцаагчийн ажлын ачаалал хэтэрсэн нь хяналт шалгалтын хамрах хүрээг хумих, баримтжуулалтын чанарыг бууруулах үндсэн нөхцөл болж байгаа бөгөөд улмаар төлөвлөгөөт ажлын хэрэгжилт саатах, гүйцэтгэлийн чанар сулрах бодит эрсдэлийг бүрдүүлж байна."*

Байх ёстой шаардлага /шалгуур/: */:* *Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23 дугаар зүйлийн 23.6-д "Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.", Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албаны тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.5.-д "Албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын чиг үүрэг, хууль тогтоомжийн дагуу боловсруулсан стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны шинжилгээнд үндэслэн боловсруулна"*

Асуудлын үндсэн шалтгаан: *Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн стратегийн түвшинд хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн бодлогыг хяналт шалгалтын хамрах хүрээ болон үйл ажиллагааны эрсдэлтэй уялдуулаагүй, удирдлагын хяналт сул байгаа нь нөөцийн дутагдал үүсэх, хяналтын механизм алдагдах суурь нөхцөл болж байна.*

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: *Удирдлагын зүгээс хүний нөөцийн төлөвлөлт болон эрсдэлийн үнэлгээг орхигдуулснаар хяналт шалгалтын чанар, хүртээмж стратегийн түвшинд суларч, байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжихгүй байх болон салбарын хэмжээнд аюул осол хуримтлагдах бодит нөлөөг үзүүлж байна.*
Зөвлөмж: *2026 оны II улиралд Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн Монополын эсрэг газрын орон нутаг дахь улсын байцаагч албан тушаалын тодорхойлолтыг яаралтай батлуулж, ТАЗ-д захиалга хүргүүлэн орон тоог нөхөх.*

Илэрсэн асуудал 3.5	*Өндөр эрсдэлтэй объектуудыг төлөвлөгөөт шалгалтад бүрэн хамруулж чадаагүй нь хяналт шалгалтын хамрах хүрээ суларх, зөрчил дутагдлыг хугацаанд нь илрүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.*
Асуудлын ангилал	*Нөлөө их*
Бодит байдал; *Хяналт шалгалтын хамрах хүрээ хангалтгүй байгаа нь тоон үзүүлэлтээс харагдаж байна. 2024 онд 'Их эрсдэлтэй' ангиллын объектуудын ердөө 27.8%-ийг шалгалтад хамруулж, үлдсэн 72.2% нь хяналтын гадуур үлдсэн байна. 2025 онд хамралт бага зэрэг өсөж 30.1%-д хүрсэн боловч нийт объектын 69.9% нь хяналтгүй хэвээр байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна. Сүүлийн хоёр жилийн дунджаар өндөр эрсдэлтэй объектуудын 71 орчим хувь нь хяналт шалгалтад хамрагдаагүй байгаа нь салбарын хэмжээнд зөрчил дутагдал хуримтлагдах, гэнэтийн осол, эрсдэл үүсэх бодит нөхцөлийг бүрдүүлж байна.*	
Асуудлын үндсэн шалтгаан: *Нөөц ба ачааллын тэнцвэргүй байдал: Хяналт шалгалтын объект 26.8%-иар өссөн боловч байцаагчдын тоо болон техникийн нөөц (унаа, төсөв) хязгаарлагдмал байгаа нь нэг хүнд ногдох ажлын ачааллыг хэтрүүлж, хамрах хүрээг хумьсан.*	
Байх ёстой шаардлага /шалгуур/: *Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1.5-д "хяналт шалгалтыг төлөвлөхдөө тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэх", 5^5.1-д "хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна", 8.1.1-д хяналт шалгалтыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, мөн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөх шаардлагыг тус тус тогтоосон.*	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: • *Аюулгүй байдлын эрсдэл: Өндөр эрсдэлтэй объектын **71%** хяналтгүй байгаа нь салбарын хэмжээнд гэнэтийн осол, техникийн саатал гарах бодит нөхцөлийг бүрдүүлсэн.* • *Эрх зүйн чадамжгүй байдал: Хяналтын хуудас зөрүүтэй байгаагаас шалтгаалж байцаагчийн гаргасан шийдвэр шүүхийн шатанд хүчингүй болох, хуулийн маргаанд өртөх аюултай.* • *Хяналтын үр нөлөө суларх: Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь байгууллагын чиг үүрэг хэлбэр төдий болох, нэр хүнд унах эрсдэлтэй.* • *Хариуцлагын сулрал: Хяналтгүй орчинд аж ахуйн нэгжүүд стандарт, техникийн зохицуулалтыг үл тоомсорлох сөрөг хандлага даамжирна.*	
*Зөвлөмж Эрсдэлийн нарийвчилсан ангилал тогтоох: "Их эрсдэлтэй" 123 объектыг дотор нь "Маш өндөр", "Өндөр", "Дунд" гэж дахин эрэмбэлж, хамгийн аюултай хэсгийг 2026 оны шалгалтад **100% хамруулах***	

5. ДҮГНЭЛТ

Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн захиргааны үйл ажиллагаа болон өргөдөл гомдлын шийдвэрлэлт зохих түвшинд хангагдсан хэдий ч эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн чанар болон дотоод хяналтын тогтолцоо нь үр дүнд суурилаагүй, засаглалын эрсдэл өндөр байна. Иймд эрсдэлийн удирдлагын механизмыг стратегийн түвшинд шинэчлэх замаар системийн шинжтэй алдааг засах нөхцөл байдалд үндэслэн ***'Сайжруулах шаардлагатай'*** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	***Дүгнэлтийн тайлбар***
Сайжруулах шаардлагатай	*Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь **'Давтамжтай' буюу 3-р түвшин**-д байна.*

6.ЗӨВЛӨМЖ

Дотоод аудитын дүгнэлтэд үндэслэн илэрсэн илэрсэн асуудыг дутагдлыг арилгах, бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор дараах 4 чиглэлээр зөвлөмжийг багцлан хүргүүлж байна. үүнд:

1. "Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, дотоод хяналтыг сайжруулах"

- ✓ *Хэлтсийн түвшинд дотоод хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлийн бүртгэл, эрсдэлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж, удирдлагын түвшинд тогтмол тайлагнах, шийдвэр гаргалтад ашиглах механизмыг бий болгох. ISO 9001 стандартын хэрэгжилтийг сэргээж, дотоод хяналтын журам болон хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, хэлтсийн үйл ажиллагаанд эрсдэлийн бүртгэл (Risk Register)-ийг нэвтрүүлэх, гүйцэтгэлийг KPI-д суурилан үнэлэх хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх, мөн дотоод хяналтын тайлан, эрсдэлийн үнэлгээний дүнг улирал тутам удирдлагад танилцуулж хэвшүүлэх.*

- ✓ *Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахын өмнө өмнөх тайлант хугацааны эрсдэлийн үнэлгээний нэгдсэн тайланг хэлтсийн нийт бүрэлдэхүүнээр хэлэлцэж, объектуудын эрсдэлийн зэрэглэл, зөрчлийн динамик болон аюулгүй байдлын нөлөөллийг бодитой тодорхойлох, улмаар үнэлгээний үр дүнг төлөвлөгөөний хамрах хүрээ, шалгалтын давтамж, хүний нөөц болон төсөв хуваарилалтыг тогтоох **стратегийн суурь үзүүлэлт** болгон албан ёсоор баримтжуулж хэвших.*

- ✓ *Хяналт шалгалтын үйл ажиллагааны бүх шатны баримт бичгийн (Жилийн төлөвлөгөө Удирдамж Хяналтын хуудас) уялдаа холбоог хангах зорилгоор эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг нэгдмэл стандарт, кодчиллын системд шилжүүлэх, удирдамж болон хяналтын хуудас дахь эрсдэлийн үзүүлэлтүүдийн зөрүүг арилгаж, стратегийн түвшний үнэлгээний үр дүнг гүйцэтгэлийн шатанд шууд хөрвүүлэн ашигладаг арга зүйн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж ажиллах.*

2. "Хяналтын баримт бичгийн сайжруулалт

- ✓ *Батлагдаагүй байгаа хяналтын хуудас, эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг салбарын яам, агентлагуудаар эцсийн байдлаар батлуулах албан бичгийг эхний хагас жилд багтаан хүргүүлж, шийдвэрлэлтэд 14 хоног тутам хяналт тавих"*
- ✓ *Шинэчлэн боловсруулах хяналтын хуудаст эрсдэлийн үзүүлэлтүүдийг бодитой тусгаж, байцаагчийн үзэмжээр хандах боломжийг хязгаарласан, хэмжих боломжтой стандарт асуултуудтай болгох.*
- ✓ *Хяналтын хуудас нь өөрөө "Захиргааны хэм хэмжээний акт" болохын хувьд дээд шатны байгууллагаар дамжуулан улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, индексжүүлэх процессыг шуурхайлах.*
- ✓ *Зөвхөн эрх бүхий байгууллагаар баталгаажсан, хүчин төгөлдөр хяналтын хуудасны дагуу шалгалт явуулахыг улсын байцаагч нарт үүрэг болгож, удирдамжтай нийцүүлэх.*

3. Салбарын хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах

Одоо байгаа 6 байцаагчийн нөөцөд тулгуурлан, их эрсдэлтэй 123 объектын хяналтыг салбар бүрээр хуваарилж, дутуу үлдсэн 86 объектыг 2026 онд багтаан төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналтаар нөхөн хамруулах

- ✓ *Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөөг бодит үр дүнтэй уялдуулах зорилгоор байцаагч нарын ажлын гүйцэтгэлийг зөвхөн 'шалгалтын тоо', 'төлөвлөгөөний биелэлт' гэх мэт тоон үзүүлэлтээр бус, харин хяналтад хамрагдсан объектуудын 'эрсдэлийн түвшин буурсан үзүүлэлт', 'зөрчлийн арилгалт' болон 'урьдчилан сэргийлсэн байдал'-ыг гол шалгуур (KPI) болгон гүйцэтгэлийн үнэлгээний шинэ тогтолцоог нэвтрүүлж хэвших."*
- ✓ *Байгууллагын эрсдэлийн мэдээллийн санг шийдвэр гаргах түвшний үндсэн хэрэгсэл болгон идэвхжүүлж, 'Их эрсдэлтэй' ангилалд багтсан боловч хяналт шалгалтад хамрагдаагүй үлдсэн объектуудыг 'Улаан бүс' анхааруулгын жагсаалтад бүртгэн, тэдгээрт чиглэсэн ээлжит бус болон гүйцэтгэлийн шалгалтын хуваарийг шуурхай боловсруулж, эрсдэлийг цаг алдалгүй хяналтад авах."*

4. Хүний нөөц ажлын ачааллыг тэнцвэржүүлэх

- ✓ *Сул орон тоог нөхөх хүртэлх хугацаанд тухайн чиглэлийн хяналтыг салбар хоорондын уялдаа холбоог ашиглан бусад байцаагч нарт түр хариуцуулан ажлын ачааллыг тэнцвэржүүлэх дотоод зохион байгуулалтыг хийх.*

Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж биелэлтийн нэгдсэн тайланг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3.6 дахь "санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх" гэж заасны дагуу дараагийн шатны арга хэмжээг хэрэгжүүлэх болохыг урьдчилан анхааруулъя.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР Д.ВАНЧИГМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА СХШУАБ Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САЛБАРЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Я.МӨРӨН